ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

**САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

Аймгийн Музейн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

**Аудитын код: БӨА-2022-12- НА-СТА-ТШЗ**

Цахим хуудас: www.audit.mn

Өлгий хот

2022 он

Төрийн аудитын газрын дарга бөгөөд тэргүүлэх аудитор: М.Хуанган

Утас: 70422954

Цахим хаяг: huanganm@audit.gov.mn

Аудитын менежер: Х.Женисбек

Утас: 70422930

Цахим хаяг: jenisbekh@audit.gov.mn

Аудитор: Х.Тилекберди

Утас: 95405553

Цахим хаяг: htilekberdi@ yahoo.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Товчилсон үгийн жагсаалт

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| АОУС | Аудитын Олон Улсын Стандарт |
| ТӨБЗГ | Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар |

## Агуулга

1.Аудитын санал, дүгнэлт ........ 3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл ........ 5
3.Аудитын тайлан ........ 5
3.1.Ерөнхий зүйл ........ 7
3.2. Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт........ 10
3.3. Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал ........ 13
3.4. Материаллаг байдал ........ 13
3.5. Санхүүгийн тайлангийн тодруулга........ 16
3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв. ........ 17
3.7. Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг........ 17
3.8. Аудитын гол асуудал........ 18
3.9. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал..... **Error! Bookmark not defined.**
3.10. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт........ **Error! Bookmark not defined.**
3.11.Дараагийн аудитаар анхаарах асуудал........ **Error! Bookmark not defined.**
4. Аудитын илрүүлэлт........ **Error! Bookmark not defined.**
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл ........ **Error! Bookmark not defined.**

## 1.ТӨРИЙН АУДИТЫН САНАЛ, ДҮГНЭЛТ

БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

83129 Өлгий, Баян-Өлгий аймаг,
Утас/Факс: (976) 7042-2954
E-mail: bayanulgii@audit.gov.mn

АЙМГИЙН МУЗЕЙН ДАРГА
А.АЙШАГУЛ ТАНАА

2022.02.25 № 202
танай ____________ -ны № ____________ -т

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

**Зөрчилгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Аймгийн Музейн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/ өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Аймгийн Музейн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн одог улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх

Muzei dugnelt-2.13

үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР М.ХУАНГАН

Muzei dugnelt-2.13

## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/Төгрөгөөр/

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **6 424 541,00** | **6 424 541,00** |
| **31** | **МӨНГӨН ХӨРӨНГӨ** | - | - |
| **311** | **Кассанд байгаа бэлэн мөнгө** | - | - |
| 31110 | Төгрөг | - | - |
| 31130 | Нэмэлт санхүүжилт | - | - |
| 31140 | Касс арилжааны банк | - | - |
| **312** | **Банкинд байгаа бэлэн мөнгө** | - | - |
| **3121** | **Төгрөг** | - | - |
| 31211 | Төрийн сангийн харилцах | - | - |
| 31213 | Арилжааны банк дахь харилцах | - | - |
| 31214 | Бусад төсөл, нөөцийн харилцах | - | - |
| 31215 | Нэмэлт санхүүжилтийн харилцах | - | - |
| 31216 | Нэмэлт санхүүжилтийн арилжааны банк | - | - |
| **33** | **АВЛАГА** | - | - |
| 33100 | Ажиллагчидтай холбогдсон авлага | - | - |
| 33200 | Төлбөртэй үйлчилгээний авлага | - | - |
| 33300 | Татаас, санхүүжилтийн авлага | - | - |
| 33400 | Зээлийн хүүгийн авлага | - | - |
| **335** | **Бусад авлага** | - | - |
| 3351 | Байгууллагаас авах авлага | - | - |
| 3352 | Хувь хүмүүсээс авах авлага | - | - |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | 6 424 541,00 | 6424541 |
| **351** | **Түүхий эд материал** | - | - |
| 35110 | Тусгай зориулалттай материал | - | - |
| 35130 | Эм боох материал | - | - |
| 35200 | Дуусаагүй үйлдвэрлэл | - | - |
| 35300 | Бэлэн бүтээгдэхүүн | - | - |
| **354** | **Хангамжийн материал** | 6 424 541,00 | 6 424 541,00 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 3 558 800,00 | 3558800 |
| 35420 | Аж ахуйн материал | 2 005 741,00 | 2 005 741 |
| 35430 | Сэлбэг хэрэгсэл | - | - |
| 35440 | Түлш, шатах тослох материал | - | - |
| 35450 | Барилгын засварын материал | - | - |
| 35460 | Хүнсний материал | - | - |
| 35470 | Бусад хангамжийн материал | 860 000,00 | 860 000,00 |
| 35500 | Биологийн хөрөнгө | - | - |
| 35600 | Мал амьтад | - | - |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **3 015 068 837,51** | **2 984 020 729.69** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 3 015 068 837,51 | 2 984 020 729.69 |
| 391 | Газар | | |
| **392** | **Биет хөрөнгө** | 2 974 793 837,51 | 2 943 745 729.69 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 1 503 566 450,00 | 1 503 566 450,00 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | (50 552 514,22) | (75 707 488.06) |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 27 980 000,00 | 27 980 000,00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | (27 980 000,00) | (27 980 000,00) |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 84 163 199,73 | 84 163 199,73 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (67 151 200,53) | (69 831 103.46) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 33 603 523,00 | 33 603 523,00 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (21 202 970,47) | (24 416 201.52) |
| 39209 | Зам, гүүрийн байгууламж | - | - |
| 39210 | Хуримтлагдсан элэгдэл | - | - |

| | | | |
|---|---|---|---|
| 39211 | Батлан хамгаалах, цэргийн зориулалттай тоног төхөөрөмж | - | - |
| 39212 | Хуримтлагдсан элэгдэл | - | - |
| 39213 | Түүх соёл, музейн дурсгалт зүйлс | 1 488 667 350,00 | 1 488 667 350,00 |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | - | - |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | - | - |
| 39216 | Дуусаагүй барилга, байгууламж | - | - |
| 39217 | Ном | 3 700 000,00 | 3 700 000,00 |
| **393** | **Биет бус хөрөнгө** | | |
| 39301 | Програм хангамж | 550 000,00 | 550 000,00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | (550 000) | (550 000,00) |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 40 275 000 | 40 275 000 |
| 39304 | Хуримтлагдсан элэгдэл | | |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **3 021 493 378,51** | **2 990 445 270.69** |
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | **15 691 068,44** | **25 865 874.00** |
| **41** | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | 15 691 068,44 | **25 865 874.00** |
| **413** | **Өглөг** | 15 691 068,44 | **25 865 874.00** |
| 41310 | Ажилчидтай холбогдсон өглөг | - | |
| 41320 | Бараа үйлчилгээний зардлын өглөг | 15 380 068,44 | 25 865 874.00 |
| 41330 | Татаас, санхүүжилт, шилжүүлгийн өглөг | - | |
| 41340 | Хөрөнгө бэлтгэхтэй холбогдсон өглөг | - | |
| 41350 | Зээлийн хүүгийн өглөг | - | |
| **4136** | **Бусад өглөг** | 311 000,00 | |
| 41361 | Байгууллагад төлөх өглөг | 311 000,00 | |
| 41362 | Хувь хүмүүст төлөх өглөг | - | |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **3 005 802 310,07** | **2 964 579 396.69** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 3 005 802 310,07 | 2 964 579 396.69 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 379 824 076,00 | 379 824 076.00 |
| 51101 | Өмч: - төрийн | 379 824 076,00 | 379 824 076.00 |
| 51102 | - хувийн | - | |
| 51103 | - хувьцаат | - | |
| 51104 | Халаасны хувьцаа | - | |
| 51105 | Нэмж төлөгдсөн капитал | - | |
| 51106 | Эздийн өмчийн бусад хэсэг | - | |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | 36 550 746,67 | (4 672 166.71) |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 77 720 697,26 | 36 550 746.67 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | (41 169 950,59) | (41 222 913.38) |
| 51230 | Давхардсан гүйлгээг цэвэрлэх данс | - | |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 2 589 427 487,40 | 2 589 427 487.40 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **3 021 493 378,51** | **2 990 445 270.69** |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/Төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|

| | | | |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **246 604 300,00** | **227 853 100.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **14 800 000,00** | **485 000.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 2 503 000,00 | 485 000.00 |
| 120001 | Хувьцааны ногдол ашиг | - | |
| 120002 | Хүүгийн орлого | - | |
| 120003 | Торгуулийн орлого | - | |
| 120004 | Төсөвт байгууллагын өөрийн орлого | - | |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | - | 485 000.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | - | |
| 1200043 | Урьд оны үлдэгдлээс санхүүжих | - | |
| 1200044 | Гадаадын эх үүсвэрээс санхүүжих | - | |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | - | |
| 120005 | Түрээсийн орлого | - | |
| 120008 | Монгол банкны ашиг | - | |
| **122** | **Тусламжийн орлого** | 14 800 000,00 | |
| 122001 | Хандив тусламж /дотоод/ | 14 800 000,00 | |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **231 804 300,00** | |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 2 503 000,00 | 3 100 000.00 |
| 131101 | Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж | - | |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | - | 3 100 000.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 2 503 000,00 | |
| 131106 | Төсвийн урамшуулал | - | |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 229 301 300,00 | 224 268 100.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 229 301 300,00 | 224 268 100.00 |
| 132002 | Засгийн газрын, Засаг даргын нөөц хөрөнгийн санхүүжилт | | - |
| 132003 | Төвлөрүүлэх шилжүүлэг /орон нутгийн төсөвт байгууллага улсад төвлөрүүлэх орлого/ | - | - |
| 132004 | Оны эхний үлдэгдлээс санхүүжих / орон нутгийн төсөв/ | - | - |
| 132005 | Хөрөнгийн санхүүжилт / орон нутгийн төсөвт байгууллага/ | - | - |
| 132006 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт / аймгаас авсан санхүүгийн дэмжлэг/ | - | - |
| 132007 | Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих | - | - |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **287 774 250,59** | **269 076 013.38** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **287 774 250,59** | **269 076 013.38** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 287 136 037,59 | 268 659 313.38 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 149 367 401,00 | 150 080 700.00 |
| 210101 | Үндсэн цалин | 131 518 562,00 | 124 735 010.00 |
| 210102 | Нэмэгдэл | 17 848 839,00 | 25 345 690.00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | - | - |
| 210104 | Урамшуулал | - | - |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | - | - |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 22 542 412,00 | 19 22 800.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 16 410 812,00 | 12 021 400.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 1 532 900,00 | 1 503 900.0 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 1 251 900,00 | 1 203 100.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 281 000,00 | 300 800.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 3 065 800,00 | 4 193 600.00 |

| | | | |
|---|---|---|---|
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 66 484 323,44 | 57 213 705.56 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 2 535 555,00 | 2 535 600.00 |
| 210302 | Түлш, халаалт | 61 452 268,44 | 332 000.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 2 496 500,00 | 1 685 400.00 |
| 210304 | Байрны түрээс | - | |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 4 536 932,00 | 2 913 790.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 623 700,00 | 585 890.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 400 400,00 | 332 000.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 709 132,00 | 602 800.00 |
| 210404 | Ном, хэвлэл | - | |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | - | |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 2 803 700,00 | 1 393 100.00 |
| 210407 | Аж ахуйн материал худалдан авах зардал | - | |
| 210408 | Бараа материал акталсны зардал | - | |
| **2105** | **Нормативт зардал** | 247 700,00 | 206 400.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | - | |
| 210502 | Хоол, хүнс | - | |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 247 700,00 | 206 400.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 100 000,00 | 570 200.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | - | - |
| 210602 | Тавилга | - | - |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 100 000,00 | 83 300.00 |
| 210604 | Урсгал засвар | - | 486 900.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 1 515 300,00 | 232 000.00 |
| 210701 | Гадаад албан томилолт | - | |
| 210702 | Дотоод албан томилолт | 1 515 300,00 | 232 000.00 |
| 210703 | Зочин төлөөлөгч хүлээн авах | - | |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 1 458 300,00 | 7 171 610.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 642 000,00 | 6 319 410.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 350 000,00 | 280 000.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 316 900,00 | 264 100.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 35 500,00 | 35 500.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 33 000,00 | 31 300.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | - | |
| 210807 | Газрын төлбөр | - | 241 300.00 |
| 210808 | Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж | 80 900,00 | |
| 210809 | Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх | - | |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 40 883 669,15 | 31 048 107.82 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | - | |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | - | |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 40 883 669,15 | 31 048 107.82 |
| 210904 | Найдваргүй авлагын алдагдал | - | |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 638 213,00 | 416 700.00 |
| **2131** | **Засгийн газрын урсгал шилжүүлэг** | - | - |
| 213101 | Засгийн газрын дотоод шилжүүлэг | - | - |
| 213102 | Засгийн газрын гадаад шилжүүлэг | - | - |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 250 000,00 | 416 700.00 |
| 213202 | Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж | - | |
| 213203 | Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж | - | |
| 213204 | Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал | - | |

| | | | |
|---|---|---|---|
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | - | |
| 213206 | Ээлжийн амралтаар нутаг явах унааны хөнгөлөлт | - | |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | - | |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | - | |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 250 000,00 | 416 700.00 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | 388 213,00 | |
| 213401 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт төсөвт байгууллага | - | |
| 213402 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт сумдад | - | |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 388 213,00 | |
| 213404 | Хөрөнгийн | - | |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **(41 169 950,59)** | **(41 222 913.38)** |
| **4** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)** | - | |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **(41 169 950,59)** | **(41 222 913.38)** |

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/Төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | | |
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **231 804 300,00** | **227 853 100.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | | **485 000.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | | 485 0000.00 |
| 120001 | Хувьцааны ногдол ашиг | | |
| 120002 | Хүүгийн орлого | | |
| 120003 | Торгуулийн орлого | | |
| 120004 | **Төсөв байгууллагын өөрийн орлого** | | 485 000.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | | 485 000.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | | |
| 1200043 | Урьд оны үлдэгдэлээс санхүүжих | | |
| 1200044 | Гадаадын эх үүсвэрээс санхүүжих | | |
| 120005 | Түрээсийн орлого | | |
| 120009 | Бусад орлого | | |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **231 804 300,00** | **227 368 100.00** |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | - | 3 100.000.00 |
| 131101 | Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж | | |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | | 3 100 000.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 2 503 000,00 | |
| 131106 | Төсвийн урамшуулал | | |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 229 301 300,00 | 224 268 100.0 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 229 301 300,00 | 224 268 100.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 132002 | Засгийн газрын, Засаг даргын нөөц хөрөнгийн санхүүжилт | | |
| 132003 | Төвлөрүүлэх шилжүүлэг /орон нутгийн төсөвт байгууллага улсад төвлөрүүлэх орлого/ | | |
| 132004 | Оны эхний үлдэгдлээс санхүүжих / орон нутгийн төсөв/ | | |
| 132005 | Хөрөнгийн санхүүжилт / орон нутгийн төсөвт байгууллага/ | | |
| 132006 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт / аймгаас авсан санхүүгийн дэмжлэг/ | | |
| 132007 | Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих | | |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **231 804 300,00** | **227 853 100.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **231 804 300,00** | **227 853 100.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **231 166 087,00** | **227 436 400.00** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 153 291 700,00 | 150 391 700.00 |
| 210101 | Үндсэн цалин | 126 527 224,84 | 120 052 435.00 |
| 210102 | Нэмэгдэл | 26 764 475,16 | 30 339 265.00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | | |
| 210104 | Урамшуулал | | |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | | |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 19 222 900,00 | 19 222 800.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 13 091 300,00 | 13 207 200.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 1 532 900,00 | 1 503 900.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 1 226 300,00 | 1 203 100.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 306 600,00 | 300 800.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 3 065 800,00 | 3 007 800.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 51 104 255,00 | 46 727 900.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 2 535 555,00 | 2 535 600.00 |
| 210302 | Түлш, халаалт | 46 072 200,00 | 42 506 900.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 2 496 500,00 | 1 685 400.00 |
| 210304 | Байрны түрээс | | |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 4 250 932,00 | 2 922 800.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 567 600,00 | 594 900.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 456 500,00 | 332 000.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 709 132,00 | 602 800.00 |
| 210404 | Ном, хэвлэл | | |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | | |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 2 517 700,00 | 1 393 100.00 |
| 210407 | Аж ахуйн материал худалдан авах зардал | | |
| 210408 | Бараа материал акталсны зардал | | |
| **2105** | **Нормативт зардал** | 247 700,00 | 206 400.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | | |
| 210502 | Хоол, хүнс | | |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 247 700,00 | 206 400.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 100 000,00 | 570 200.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | | |
| 210602 | Тавилга | | |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 100 000,00 | 83 300.00 |
| 210604 | Урсгал засвар | | 486 900.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 551 800,00 | 232 000.00 |
| 210701 | Гадаад албан томилолт | | |
| 210702 | Дотоод албан томилолт | 551 800,00 | 232 000.00 |
| 210703 | Зочин төлөөлөгч хүлээн авах | | |

| | | | |
|---|---|---|---|
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 2 396 800,00 | 7 162 600.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 1 605 500,00 | 6 310 400.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 350 000,00 | 280 000.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 316 900,00 | 264 100.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 35 500,00 | 35 500.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 33 000,00 | 31 300.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | | |
| 210807 | Газрын төлбөр | | 241 300.00 |
| 210808 | Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж | 55 900,00 | |
| 210809 | Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх | | |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **638 213,00** | **416 700.00** |
| **2131** | **Засгийн газрын урсгал шилжүүлэг** | - | |
| 213101 | Засгийн газрын дотоод шилжүүлэг | | |
| 213102 | Засгийн газрын гадаад шилжүүлэг | | |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 250 000,00 | |
| 213202 | Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж | | |
| 213203 | Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж | | |
| 213204 | Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал | | |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | | |
| 213206 | Ээлжийн амралтаар нутаг явах унааны хөнгөлөлт | | |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | | |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | | |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 250 000,00 | 416 700.00 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | 388 213,00 | |
| 213401 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт төсөвт байгууллага | | |
| 213402 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт сумдад | | |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 388 213,00 | |
| 213404 | Хөрөнгийн | | |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | - | |
| | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | | |
| 140008 | Хүлээн авсан ногдол ашиг | | |
| **5** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)** | - | |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | - | |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | - | |
| 220001 | Барилга байгууламж | | |
| 221001 | Их засвар | | |
| 222001 | Тоног төхөөрөмж | | |
| 223001 | Бусад хөрөнгө | | |
| 224001 | Стратегийн нөөц хөрөнгө | | |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | | |
| **6** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)** | | - |
| | **САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | | |
| **7** | **САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | - | - |

| | | | |
|---|---|---|---|
| **8** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)** | - | - |
| **9** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | |
| **10** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | | |

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/ төгрөгөөр /

| **Код** | **Үзүүлэлт** | **Засгийн газрын оруулсан капитал** | **Дахин үнэлгээний нөөц** | **Хуримтлагдсан дүн** | **Засгийн газрын хувь оролцооний нийт дүн** |
|---|---|---|---|---|---|
| C01 | **2020 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | 379 824 076,00 | 2 589 427 487,40 | 36 550 746.67 | 3 005 802 310,07 |
| C02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | | | | |
| C03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **379 824 076,00** | **2 589 427 487,40** | 36 550 746.67 | 3 005 802 310,07 |
| C04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт | | | | |
| C05 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт | | | | |
| C06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | | | | |
| C07 | Тайлант үеийн үр дүн | | | | |
| C08 | **2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **379 824 076,00** | **2 589 427 487,40** | 36 550 746.67 | 3 005 802 310,07 |
| D01 | **2020 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | **379 824 076,00** | **2 589 427 487,40** | 36 550 746.67 | 3 005 802 310,07 |
| D02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | | | | |
| D03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **379 824 076,00** | **2 589 427 487,40** | 36 550 746.67 | 3 005 802 310,07 |
| D04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт | | | | |
| D05 | Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт | | | | |
| D06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | | | | |
| D07 | Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү | | | | |
| D08 | Тайлант үеийн үр дүн | | | -41 222 913.38 | -41 222 913.38 |
| D09 | **2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **379 824 076,00** | **2 589 427 487,40** | **-4 672 166.71** | 2 964 579 396.69 |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

**/ төгрөгөөр /**

| | **Үзүүлэлт** | **Тайлант оны** |
|---|---|---|

| Эдийн засгийн ангилал | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | 224 268 100.00 | 224 268 100.00 |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 224 268 100.00 | 224 268 100.00 |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 223 851 400.00 | 223 851 400.00 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 150 391 700.00 | 150 391 700.00 |
| 210101 | Үндсэн цалин | 120 515 000.00 | 120 515 000.00 |
| 210102 | Нэмэгдэл | 29 876 700.00 | 29 876 700.00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | | |
| 210104 | Урамшуулал | | |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | | |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 19 222 800.00 | 19 222 800.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 13 207 200.00 | 13 207 200.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 1 503 900.00 | 1 503 900.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 1 203 100.00 | 1 203 100.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 300 800.00 | 300 800.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 3 007 800.00 | 3 007 800.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 46 727 900.00 | 46 727 900.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 2 535 600.00 | 2 535 600.00 |
| 210302 | Түлш, халаалт | 42 506 900.00 | 42 506 900.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 1 685 400.00 | 1 685 400.00 |
| 210304 | Байрны түрээс | | |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 2 437 800.00 | 2 437 800.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 594 900.00 | 594 900.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 332 000.00 | 332 000.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 602 800.00 | 602 800.00 |
| 210404 | Ном, хэвлэл | | |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | | |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 908 100.00 | 908 100.00 |
| 210407 | Аж ахуйн материал худалдан авах зардал | | |
| **2105** | **Нормативт зардал** | 206 400.00 | 206 400.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | | |
| 210502 | Хоол, хүнс | | |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 206 400.00 | 206 400.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 570 200.00 | 570 200.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | | |
| 210602 | Тавилга | | |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 83 300.00 | 83 300.00 |
| 210604 | Урсгал засвар | 486 900.00 | 486 900.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 232 000.00 | 232 000.00 |
| 210701 | Гадаад албан томилолт | | |
| 210702 | Дотоод албан томилолт | 232 000.00 | 232 000.00 |
| 210703 | Зочин төлөөлөгч хүлээн авах | | |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 4 062 600.00 | 4 062 600.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 3 210 400.00 | 3 210 400.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 280 000.00 | 280 000.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 264 100.00 | 264 100.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 35 500.00 | 35 500.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 31 300.00 | 31 300.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | | |

| | | | |
|---|---|---|---|
| 210807 | Газрын төлбөр | 241 300.00 | 241 300.00 |
| 210808 | Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж | | |
| 210809 | Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх | | |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 416 700.00 | 416 700.00 |
| **2131** | **Засгийн газрын урсгал шилжүүлэг** | | |
| 213101 | Засгийн газрын дотоод шилжүүлэг | | |
| 213102 | Засгийн газрын гадаад шилжүүлэг | | |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 416 700.00 | 416 700.00 |
| 213202 | Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж | | |
| 213203 | Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж | | |
| 213204 | Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал | | |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | | |
| 213206 | Ээлжийн амралтаар нутаг явах унааны хөнгөлөлт | | |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | | |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | | |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 416 700.00 | 416 700.00 |
| **13** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | | |
| **1310** | **УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | | |
| 131001 | Улсын төсвөөс санхүүжих | | |
| 131006 | Засгийн газрын тусгай сангаас санхүүжих | | |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | | |
| 131008 | Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас санхүүжих | | |
| **1320** | **ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 224 268 100.00 | 224 268 100.00 |
| 132001 | Орон нутгийн төсвөөс | 224 268 100.00 | 224 268 100.00 |
| 132007 | Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих | | |
| **120004** | **ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС** | | |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | | |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | | |
| 1200043 | Урьд оны үлдэгдлээс санхүүжих | | |
| 1200044 | Гадаадын эх үүсвэрээс санхүүжих | | |
| **4** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | |
| **5** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | | |
| **6** | **ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ** | | |
| **61** | **БАЙГУУЛЛАГЫН ТОО** | 1,00 | 1,00 |
| 610001 | Төсвийн байгууллага | 1,00 | 1,00 |
| 610002 | Төсвөөс гадуур байгууллага | | |
| **62** | **АЖИЛЛАГСАДЫН ТОО** | 17,00 | 17,00 |
| 620001 | Удирдах ажилтан | 1,00 | 1,00 |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 8,00 | 8,00 |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 8,00 | 8,00 |
| 620004 | Гэрээт ажилтан | | |
| **65** | **ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ** | **17,00** | **17,00** |
| 650001 | Төрийн захиргааны албан хаагч (ТЗ) | | |
| 650002 | Төрийн тусгай албан хаагч (ТТ) | | |
| 650003 | Ажлын албаны албан хаагч (АА) | | |
| 650004 | СЄБ болон бага, дунд боловсролын албан хаагч (ТҮБД) | | |
| 650005 | ШУ-ны салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮШУ) | | |
| 650006 | Соёл урлагийн салбарын төрийн їйлчилгээний албан хаагч (ТҮСУ) | 9,00 | 9,00 |
| 650007 | Мэргэжлийн боловсролын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮМБ) | | |
| 650008 | Эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮЭМ) | | |

| | | | |
|---|---|---|---|
| 650009 | Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ) | 8,00 | 8,00 |
| 650010 | Гэрээт ажилтан | | |
| 650011 | Улс төрийн албан хаагч (УТ) | | |

## 2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

/ төгрөгөөр /

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх он | Гүйцэтгэл |
|---|---|---|---|
| | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | |
| **I** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **2 503 000,00** | **3 585 000.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **2 503 000,00** | **3 585 000.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 2 503 000,00 | 3 585 000.00 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | - | |
| 210101 | Үндсэн цалин | | |
| 210102 | Нэмэгдэл | | |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | | |
| 210104 | Урамшуулал | | |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | | |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | - | |
| 210201 | Тэтгэврийн даатгал | | |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | | |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | | |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | | |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | | |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 2 503 000,00 | 485 000.00 |
| 210401 | Бичиг хэрэг | | |
| 210402 | Тээвэр, шатахуун | | |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 400 000,00 | |
| 210404 | Ном, хэвлэл | | |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | | |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 2 103 000,00 | 485 000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | - | 3 100 000.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | | 3 100.000.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | | |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | | |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | | |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | | |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | | |
| 210807 | Газрын төлбөр | | |
| 210808 | Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж | | |

| | | | |
|---|---|---|---|
| 210809 | Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх | | |
| **II** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 2 503 000,00 | 3 585 000.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 2 503 000,00 | 3 585 000.00 |
| 131101 | Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж | | |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | | 3 100 000.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 2 503 000,00 | 485 000.00 |
| 131106 | Төсвийн урамшуулал | | |
| **IV** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)** | | |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | | |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | | |

## 3.Аудитын тайлан

### 3.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1, “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Аймгийн Музейн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын дүгнэлт түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд цалинтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг “Ужим алтай Аудит” ХХК-ны аудитор Х.Тилекберди нар гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Х.Женисбек, газрын дарга, тэргүүлэх аудитор М.Хуанган нар тус тус хэрэгжүүлсэн.

Аймгийн Музейн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 сарын 19-ний өдрийн 06 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

### 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Байгууллагын зорилго, зорилт, үйл ажиллагааны чиглэл.

Аймгийн Музейн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Соёлын өвийг хадгалан хамгаалах, олон нийтэд түгээн дэлгэрүүлэх, хойч үедээ өвлүүлэн үлдээх, соёлын биет болон биет бус өвийн мэдлэгийг дээшлүүлэхэд оршино.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт ороогүй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитороос шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

Аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, аудитын албанаас 2020 онд Аймгийн Музейн 2019 оны үйл ажиллагаанд аудит хийсэн байна.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Аймгийн Музейн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

### 3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг "дунд" гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 287.4 сая төгрөгөөс 1.5 хувиар 4.3 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар 3.2 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Аймгийн Музейн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 31.0 сая төгрөгөөр буюу 1.0 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан үндсэн хөрөнгө, өглөг данс байна.

*Хүснэгт 1.* Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Мөнгөн хөрөнгө | | | |
| Авлага | | | |
| Урьдчилгаа | | | |
| Бараа материал | 6424,5 | 6424,5 | 0,0 |
| Үндсэн хөрөнгө | 3015068,8 | 2984020,7 | -31048,1 |
| **Нийт хөрөнгө** | **3021493,4** | **2990445,3** | **-26083,6** |
| Өр төлбөр | 15691,1 | 25865,9 | 10174,8 |
| Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/ | 3005802,3 | 2964579,4 | -41222,9 |
| **Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн** | **3021493,4** | **2990445,3** | **-31048,1** |

Мөнгөн хөрөнгө, авлага данс үлдэгдэлгүй байна.

Бараа материалын дансны оны эхэн ба эцэст 6.4 сая төгрөгийн үлдэгдэлтэй өөрчлөлт ороогүй байна. Оны эцсийн бараа материалын үлдэгдлийн 3.5 сая төгрөг нь бичиг хэргийн, 2.0 сая төгрөг нь аж ахуйн материалын, 0.9 сая төгрөг нь бусад хангамжийн бараа материалын үлдэгдэл байна.

Тайлант онд 2.5 сая төгрөгийн бараа материалыг худалдан авч, зарцуулсан байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 31.0 сая төгрөгөөр буурсан нь тайлант оны элэгдлийн зардалтай холбоотой байна. Тайлант онд үндсэн хөрөнгө дансанд хөдөлгөөн гараагүй байна.

Тайлант онд биет бус хөрөнгийн дүнд ямар нэгэн өөрчлөлт ороогүй байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл 25.8 сая төгрөгөөр өссөн нь түлш халаалтын өглөг 10.1 сая төгрөгөөр нэмэгдсэн нь нөлөөлсөн байна. Оны эхний байгууллагад төлөх 0.3 сая төгрөгийн бусад өглөгийг барагдуулсан байна. Шүүхийн шийдвэрийн дагуу 2017 оноос 15.3 сая төгрөгийн халаалтын өглөгийг тайланд нэмж тусгасан байна.

Тус газарт урт хугацаат өр төлбөр байхгүй байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 41.2 сая төгрөгөөр буурсан нь тайлант онд -41.2 сая төгрөгийн үр дүнтэй гарснаас шалтгаалжээ. Засгийн газрын капиталын дүнд өөрчлөлт ороогүй байна.

Аймгийн Музейн санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 18.7 сая төгрөгөөр буюу 7.6 хувиар буурсан байна.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан орон нутгийн төсвийн санхүүжилтийн орлого, үнэт төлбөргүй хүлээн авсан орлого байна. Энэ нь 2021 онд түлш халаалтын зардлын өр өссөнтэй холбоотой төсөв хүрэлцээгүй гэж үзэх үндэстэй.

Нийт зардал өмнөх оноос 18.3 сая төгрөгөөр буюу 6.4 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан НДШ, байр ашиглалттай холбоотой зардал, албан томилолт, БҮТЭЗүйл, үндсэн хөрөнгийн элэгдлийн зардал байна.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар үр дүн 4.1 сая төгрөг байна.Өмнөх оны үр дүнд ямар нэгэн залруулга хийгдээгүй байна.

### 3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 308.2 сая төгрөгөөр, нийт зарлагыг 308.2 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна. Санхүүжүүлэх эх үүсвэрийн хувьд орон нутгийн төсвөөс 209.2 сая төгрөгийг, үндсэн үйл ажиллагааны орлогоос 15.0 сая төгрөгийг бүрдүүлэхээр санал хүргүүлсэн байна.

Аймгийн Музейн 2021 оны төсвийг Аймгийн ИТХ-ын хуралдааны 2020 оны 12 дугаар сарын 09-ны өдрийн 16 дугаар тогтоолоор 224.2 сая төгрөгөөр баталж 209.2 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс, 15.0 сая төгрөгийг үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Аймгийн ИТХ-ын хуралдааны 2021 оны 8 дүгээр сарын 09-ны өдрийн 41 дүгээр тогтоолоор тодотголт хийж нийт төсвийг 224.2 сая төгрөгөөр хэвээр нь баталж, орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр тусгасан байна. Ковид-19 цар тахлын улмаас музейн үзмэр үзэх жуулчид байхгүй болсны улмаас үндсэн үйл ажиллагааны орлого 15.0 сая төгрөгийг хасаж өгсөн байна.

#### 3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 3 хөтөлбөрийн 20 арга хэмжээг санхүүжүүлэхээр 224.2 сая төгрөгийн төсөв батласнаас гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 224.2 сая төгрөгийн санхүүжилтийг авч, урсгал үйл ажиллагаанд 224.2 сая төгрөгийг зарцуулсан байна. Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 224.2 сая төгрөг буюу 100 хувьтай байна.

#### 3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд үндсэн үйл ажиллагааны орлогоос 0.5 сая төгрөгийн орлогыг оруулж, нэмэлт санхүүжилтийн эрх нээлгэж бага үнэтэй, түргэн элэгдэх, аж ахуйн эд зүйлс худалдан авахад зарцуулсан байна. Дээд шатны төсвийн захирагчаас 3.1 сая төгрөгийн санхүүжилт авч Бөхөн уулын хаднаас олдсон олдворыг сэргээн засварлах ажил үйлчилгээний хөлсөнд зарцуулжээ.

### 3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Аймгийн Музейн 2021 оны санхүүгийн тайланд холбогдох бүх мэдээллийг толилуулж, тодруулсан байна.

Тайлант онд "Эрчим" ХХК-д халаалтын зардалд батлагдсан 42.5 сая төгрөгийг бүрэн төлсөн боловч оны эцэст 25.6 сая төгрөгийн өглөгтэй гарч өглөг оны эхнээс 10.4 сая төгрөгөөр нэмэгдсэн байна. Энэ нь халаалтын зардлын төсвийг сургуулийн төсөвт дутуу суулгасан, төсвийн төлөвлөлттэй холбоотой асуудал байна.

### 3.8 Аудитын гол асуудал

АОУС 701.8-д тодорхойлсон аудитын гол асуудлын хүрээнд тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудал гараагүй.

Материаллаг буруу тайлагналын өндөр үнэлэгдсэн эрсдэл, нөлөө бүхий эрсдэл, удирдлагын үлэмж хэмжээний шийдэл орсон асуудал, тайлант хугацаанд гарсан нөлөө бүхий ажил гүйлгээ гараагүй байна.

### 3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

#### 3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага нь тус хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т /шилэн дансны мэдээлэл/ тус тус заасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Аймгийн Музей нь 2021 онд нийт 227.8. сая төгрөгийн 149 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 227.8. сая төгрөгийн 143 мэдээллийг хугацаанд байршуулан, 6 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.Шилэн дансны 5.0 сая төгрөгөөс дээш үнийн дүнтэй 8 гүйлгээг түүвэрлэн шалгаж үзэхэд зөрчил дутагдал илрээгүй. Шилэн дансны цахим хуудсанд мэдээллийг 100% байршуулсан байна.

#### 3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжиийн холбогдох заалттай нийцсэн, батлагдсан төсвийн зарцуулалт нь төсвийн тухай хууль тогтоомжийг холбогдох заалтуудтай нийцсэн байна гэж дүгнэлээ.

### 3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны аудитаар шилэн данстай холбоотой 1 зөвлөмж өгснийг давтан шалгаж үзэхэд зөвлөмжийг хэрэгжүүлсэн байна.

### 3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй байна.

## 4. Аудитын илрүүлэлт

Аудитаар алдаа зөрчил илрээгүй.

4.1 Залруулсан алдаа

Байхгүй

4.2 Төлбөрийн акт

Байхгүй

4.3 Албан шаардлага

Байхгүй

4.4 Зөвлөмж

*1. Илрүүлэлт:*

Тайлант хугацаанд оруулбал зохих 149 мэдээллээс 6 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан боловч оруулсан мэдээлэл 96% байна.

*2. Өгсөн зөвлөмж:*

Шилэн дансны тухай хууль болон Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын холбогдох заалтуудыг мөрдөн ажиллаж, шилэн дансны мэдээллийг хугацаанд нь бүрэн байршуулж байх.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

| д/д | Аудитад хамрагдсан байгууллагын нэр | Нийт алдаа, зөрчлийн | | Үүнээс | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Залруулга | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |

| | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | Музей | 1 | | | | | | | | 1 | |